



Татварын талаарх илэн далангүй яриа

УИХ-д өргөн барьсан хүн амын орлогын албан татварын хуулийн төсөл
II Хэсэг: Хуулийн талаарх нэмэлт мэдээлэл



Хүн амын орлогын албан татварын хуулийн төсөлд татварын хувь, хэмжээнд өөрчлөлт орсноос гадна хувь хүмүүсийн орлогын эх үүсвэрийг илүү олон талаас нь авч үзсэн байна. Энэ нь хуулийг олон улсын жишигт нийцүүлэх нэгэн алхам юм. Хуулийн эдгээр өөрчлөлтийг хэлэлцэн баталснаар Засгийн газар эдийн засгийн өсөлтийг хангаж, түүний үзүүлэлтийг илүүтэй хянаж чадах юм. Дараах өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгасан байна.

- Хуулийг нэг мөр ойлгох зорилгоор хуулийн зарим нэр томъёог тайлбарласан заалтыг хуулийн төсөлд тусгав. Үүний үр дүнд татвар төлөгчийн статус тодорхой болж зохистой хэмжээний орлогын албан татварыг төлөх боломжтой болно. Тухайлбал, малчин өрх, мал бүхий этгээд, гадаад улсад олсон орлого, суутгагч гэсэн нэр томъёог тайлбарласан заалтыг тусгалаа.
- Одоогийн мөрдөж байгаа хуулиар төлбөрт таавар, бооцоот тоглоом эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод ногдуулах албан татвар нь аж ахуйн нэгжийн хувьд 40, иргэний хувьд 10 хувиар тус тус тогтоосон байдаг. Энэ зөрүүтэй байдлыг өөрчлөх зорилгоор уг орлогод 30 хувиар албан татвар ногдуулж байхаар хүн амын орлогын албан татварын хуулийг шинэчлэн найруулаад байна. Үүний үр дүнд иргэдийн бооцоот тоглоомын оролцоо буурч аажмаар аж ахуйн нэгжид уг үйл ажиллагаа шилжих юм.
- Хуулийн төсөлд оршин суугч болон оршин суугч бус албан татвар төлөгчийн ялгааг сайтар тайлбарласан бөгөөд үргэлжилсэн 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын иргэн харьяалалгүй хүнийг оршин суугч этгээдэд хамааруулахаар тусгасан байна. Энэ нь бүх оршин суугч татвар төлөгч гадаад улсад олсон орлогоосоо татвар төлөх тухай чухал заалт юм. Харин оршин суугч бус татвар төлөгч нь зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон орлогоосоо албан татвар төлнө.
- Хуулийн төсөлд анх удаа орлогыг түүний эх үүсвэрээр нь ангилсан. Ерөнхий ангилал нь үндсэн болон үндсэн бус орлогоос бүрдэж байна. Үндсэн бус орлогод цалин, хөдөлмөрийн хөлс, хувь хүний хүчин чармайлтаар (урлагийн тоглолт, шагнал, урамшуулал г.м.) олсон орлогоос бусад орлого хамаарна. Үүнийг хөрөнгийн болон хөрөнгийн хөдлөлийн орлого гэж ангилсан. Хөрөнгийн орлогод түрээс, эрхийн шимтгэл, хүүгийн г.м. орлого, хөрөнгийн хөдлөлийн орлогод хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогууд хамаарна.
- Хуулийн төсөлд шууд бус орлогыг тодорхойлж тусгалаа. Энэ нь ажил олгогчоос ажилтандаа цалин, хөлс, шагналаас гадна олгож буй тэтгэмж юм. Тухайлбал, үзвэр үйлчилгээ, эмнэлэг, орон сууц, тээврийн хэрэгсэл ашиглуулсны төлбөр зэрэг үүнд хамаарна. Харин энэ орлогод албан татвар ногдуулах нь иргэдэд татварын дарамт болохоор байгааг харгалзан татвараас чөлөөлөх орлогод хамааруулах нь зүйтэй гэж Засгийн газар үзлээ.
- Зарим аж ахуйн нэгж, байгууллагууд ажилтандаа хоол, тээврийн зардлын хөнгөлөлтийг цалинд нь тооцон олгодог. Ажилтны татварын дарамтыг бууруулах зорилгоор уг заалтыг хэрэгжүүлдэг. Үүнийг бүх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд адил байлгах үүднээс уг заалтыг хуулийн төслөөс хасч эдгээр хөнгөлөлтөд татвар ногдуулахаар болсон байна. Харин аж ахуйн нэгжийн хувьд энэ зардал нь татвараас хасагдах зардал байх юм.

Татвар төлөгчид өргөн барьсан хуулиудын төслийг "Нээлттэй засаг" вэб сайт www.open-government.mn (Монгол, Англи хувь) болон Улсын Их Хурлын вэб сайт www.parl.gov.mn (Монгол хувь)-аас үзэж болно. Иргэдээс санал авах зорилгоор дор дурдсан вэб сайтаас гадна олны танил болсон бусад вэб сайтуудад уг нийтлэлийг мөн гаргаж байгаа юм. Та бүхэн санал, сэтгэгдлээ үлдээнэ үү.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэтгэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулж буй цуврал хэлэлцүүлгийн аравдугаар хэсэг юм. Та бүхэн уг цувралын электрон хувилбарыг "Нээлттэй засаг" вэб сайт (www.open-government.mn), Сангийн яамны вэб сайт (www.mof.pmis.gov.mn), УТЕГ-ын вэб сайт (www.mta.mn)-аас үзэж, саналаа ирүүлж болно.